

**Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын
Засгийн газрын хооронд нисэхийн эрэн хайх,
авран туслах салбарт хамтран ажиллах тухай
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохирогч талууд" гэж нэрлэх/,

Монгол Улс болон Оросын Холбооны Улс 1944 оны Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцид /цаашид "конвенц" гэж нэрлэх/ нэгдэн орсныг анхааралдаа аван,

хөрш зэргэлдээ орнуудын эрэн хайх, авран туслах албадын хамтын ажиллагааны талаархи Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийг харгалзан, аюулд нэрвэгдсэн хүмүүст шуурхай тусламж үзүүлэх нь амин чухал үйлс гэдгийг ухамсарлан,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов.

1 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн зорилгод нийцүүлэн конвенцийн 12 дугаар хавсралтын 1 дүгээр бүлэгт дурдсан нэр томъёо болон тодорхойлолтыг хэрэглэнэ.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч талууд эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг энэхүү хэлэлцээрийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ. Уг үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх үндэс болгон конвенцийн 12 дугаар хавсралт, Олон улсын нисэхийн болон тэнгисийн эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны удирдамж (ИМО/ИКАО) зэргийг ашиглана.

3 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч талууд өөрсдийн улсын хөрш зэргэлдээ газар нутаг болон нислэгийн мэдээллийн залгаа бүс хоорондын хилийг өөрсдийн агаарын навигацийн зорилго бүхий эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны бүсийн хил хэмээн үзнэ. Монгол Улс болон Оросын Холбооны Улсын эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны бүсийн энэхүү зааглал нь улсын хилд үл харшилна.

2. Хэлэлцэн тохирогч тал бүр нь өөрийн эрэн хайх, авран туслах бүсэд цаашид эрэн хайх, авран туслах алба гэж нэрлэх агаарын болон газрын албадыг байлгана. Эдгээр алба 24 цагийн жижүүрлэлтэнд байна.

3. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын талаар болон эдгээр байгууллагатай холбогдох аливаа еөрчлөлтийн талаар дипломат шугамаар харилцан мэдэгдэнэ.